

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН “ОЮУНЛАГ ДАРХАНЧУУД” ДЭД ХӨТӨЛБӨР**(2021-2024 ОН)****НЭГ. ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛСАН ҮНДЭСЛЭЛ, ШААРДЛАГА**

Өсвөр үеийн хүүхэд залууст эерэг үлгэр дууриал үзүүлж, сонирхол төлөвшлийг дэмжих, өөртөө итгэх итгэл, алсын хараатай амьдралыг олж нээхэд нь туслалцаа болохуйц хөгжлийн шат дараалсан оновчтой ажлууд зохион байгуулах хэрэгцээ байгааг “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогод “эх хэл, эх түүх, өв соёлыг” нийт хүн амд төлөвшүүлж, үндэсний ижилсэл-ондоошлын гүн ухамсар, дархлаатай үндэстэн-улс байгуулахад тулгуур болохуйц нэгдмэл үнэт зүйлсийг цогцлооно” гэж заасан билээ.

Дархан хотын цаашдын хөгжил дэвшилд эрдэм боловсролд тэмүүлсэн иргэдийг бий болгох, үндэсний бичиг, уламжлалт зан заншлаа хөгжүүлж, ард иргэд, хүүхэд залуусын ном эрдэмд шимтэн нөхөрлөх хандлагыг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага байна. Нөгөөтэйгүүр даяарчлал, технологийн дэвшлийн эрин хувь хүн, байгууллага төдийгүй орон нутаг, улс орнуудын хувьд түвшин түвшиндээ бусадтайгаа өрсөлдөх өөрчлөлтийг хийх гарцаагүй хэрэгцээ шаардлага тулгамдаж байна. Энэхүү өөрчлөлт нь тодорхой үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалтын хэлбэрүүдэд өөрчлөлт оруулахаас гадна нийгмийн үнэт зүйл, сэтгэлгээ зэрэг дотоод хүчин зүйлийг ч өөрчлөх хэрэгцээ шаардлагыг бий болгож байна.

Шинжлэх ухаан, судалгааны ажлуудад иргэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх Инноваци, мэдлэг шингэсэн төслүүдийг дэлхийн улс орнуудад чухалчлан хэрэгжүүлж байна. Энэ үйл ажиллагаанд олон нийтийн оролцоотой хяналт, үр дүн нь эрдэм шинжилгээний бүлгүүдийн чадавхийг сайжруулах замаар эрдэм шинжилгээний судалгааны ажилд ахиц дэвшил гаргахаас гадна олон нийтийн шинжлэх ухааны талаарх ойлголтыг нэмэгдүүлэх талаарх хүчин чармайлтыг хэлдэг. Олон нийтийн оролцоотой хяналт, үр дүн нь эрдэм шинжилгээний бүлгүүдийн чадавхийг сайжруулах замаар эрдэм шинжилгээний судалгааны ажилд ахиц дэвшил гаргахаас гадна ард иргэдийн шинжлэх ухааны талаарх ойлголтыг нэмэгдүүлэх ач холбогдолтой юм.

ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО

Иргэдийн дунд шинжлэх ухаанч үзэл санааг бүтээлчээр хөгжүүлж хүнлэг энэрэнгүй ёс суртахуунтай, үндэсний хэл бичгийн мэдлэг, чадвар, тасралтгүй бүтээлчээр суралцдаг “**Оюунлаг Дархан**”-ы иргэдийг төлөвшүүлэх, хөгжүүлэх

ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ

“Оюунлаг Дархан” хөтөлбөрийн хүрээнд дараах үндсэн зорилтуудыг тавьж байна.

- 3.1. Шинжлэх ухаанч үзэл санааг түгээн дэлгэрүүлэх, иргэдийн оролцоог хангах
- 3.2. Үндэсний хэл соёлоо дээдлэх, монгол бичиг сурах хөдөлгөөнийг нийтийн хэмжээнд өрнүүлэх
- 3.3. Хотын соёлыг иргэн бүрт төлөвшүүлэх, иргэншсэн нийгэмд тухайн хүний амьдрах зөв хэвшлийг бий болгож, нийт олны эрх ашигт захирагдан гэгээрэх хандлагыг төлөвшүүлэх
- 3.4. Соёлт хүн төрөлхтний эрхэм зүйл болох ном унших соёл, номтой нөхөрлөх

хөдөлгөөнийг нийтэд түгээн дэлгэрүүлэх

3.5. Хүүхэд, залуучуудын оюуны чадамжийг хөгжүүлэх үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулах

ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ, БАРИМТЛАХ ЗАРЧИМ

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараах үндсэн зарчмуудыг баримтална.

- Шинжлэх ухаанч хандлагыг нийгмийн бүхий л хүрээнд дэлгэрүүлэх, танин мэдэхүй, шинжлэх ухааны холбогдолтой үйл ажиллагаануудыг цар хүрээг өргөжүүлж иргэдийг энэхүү үйл ажиллагаанд өргөнөөр татан оролцуулах
- Мэдээллийн технологийн ололт амжилтанд үндэслэн цахимаар мэдээлэл солилцох, шийдвэр гаргах, түүнчлэн талуудын үйл ажиллагааг уялдуулах, цахим технологид үндэслэсэн үйл ажиллагаануудыг дэмжих
- Төрийн болон төрийн бус байгууллага, иргэний нийгмийн оролцоо, иргэд гадаадын сонирхогч бүх талын дэмжлэгт түшиглэх
- Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх бүх арга хэмжээнд үйл ажиллагаанд цахим технологийн тэргүүн шийдлүүдийг хослуулан хэрэглэх
- Хөтөлбөрийн ажлууд нь харилцан уялдаа холбоог сайтар хангасан, мэдээллийн нэгдсэн орчинг бүрдүүлсэн, үр дүнг чухалчилсан, ажлын бүтээмжийг дээшлүүлсэн байхаар хийгдэх
- Гэр бүл, олон нийт, иргэний нийгмийн байгууллагын олон талт оролцоог хангах

ТАВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД

5.1. Шинжлэх ухаанч үзэл санааг түгээн дэлгэрүүлэх, судалгаа ба хөгжлийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах

5.1.1 Шинжлэх ухаанч танин мэдэхүйн уралдаан тэмцээнүүдийг зохион байгуулах

5.1.2 Их дээд мэргэжлийн сургуулиудын багш, оюутнуудын дунд Дархан хотын хөгжлийн тулгамдсан асуудлаар ЭШ-ий хурал зохион байгуулах

5.1.3 Эрдэм шинжилгээний хүрээлэн, судалгааны төвүүдийн зүгээс иргэдийн аж ахуй эрхлэлтэй холбоотой зөвлөгөө мэдээллээр тогтмол хангах

5.1.4 Шинжлэх ухааны танин мэдэхүйн буланг үзвэр үйлчилгээний газрууд, мэдээллийн технологийн томоохон компаниудад сонирхолтой байдлаар байгуулан шинжлэх ухааныг сурталчлах

5.1.5 Их дээд сургуулиуд, политехник коллежууд, эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийн нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулж иргэдэд шинжлэх ухаан технологийн ололт амжилтыг сурталчлах

5.1.6 **Шинжлэх ухааны** үйл ажиллагааг нийтэд түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг бодлого төлөвлөгөөтэй авч хэрэгжүүлэх “Иргэдийн эксперт” зөвлөл байгуулж ажиллуулах, Аймгийн эрдэмтдийн зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах

5.2. Үндэсний хэл соёлоо дээдлэх, монгол бичиг сурах хөдөлгөөнийг нийтийн хэмжээнд өрнүүлэх

5.2.1. Үндэсний соёл, ёс заншлаа сурталчлах, түгээн дэлгэрүүлэх арга хэмжээнүүдийг ЕБС, цэцэрлэгүүд дээр хүүхэд багачуудын насны онцлогт тохируулан тогтмол зохион байгуулах

- 5.2.2. Төрийн албан хаагчид, иргэдийн дунд монгол бичгийн сургалт зохион байгуулах
- 5.2.3. Мэргэжлийн хөгжлийн бүлгүүдийн /Бага ангийн болон ахмад багш/ санаачлагаар монгол бичиг эхлэн суралцагч, сонирхогчдод хичээл заах боломжийг хөхүүлэн дэмжих
- 5.2.4 Үндэсний бичгийн багш нарын онол, заах арга зүйн төвлөрсөн болон бүсчилсэн сургалт / Багш солилцоо хөтөлбөр / зохион байгуулах;
- 5.2.5. Ерөнхий боловсролын сургуулиудад Монгол бичгийн танхимыг байгуулах
- 5.2.6. Аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудын дунд “Монгол бичигтэн” болох аяныг өрнүүлэх;

5.3. Хотын соёлыг иргэн бүрт төлөвшүүлэх, иргэншсэн нийгэмд тухайн хүний амьдрах зөв хэвшлийг бий болгож, нийт олны эрх ашигт захирагдан гэгээрэх хандлагыг төлөвшүүлэх

- 5.3.1. “Хотын соёл надаас эхэлнэ” илтгэл хэлэлцүүлэг, эсээ бичлэг, шторк, уриалга, постеруудыг цахим хуудас, телевизийн сувгаар зохион байгуулах (Иргэн бүр хотод амьдрах зөв хэвшилтэй болсноор байгаль дэлхийгээ хайрлах, ан амьтныг өрөвдөж энэрэх, бусдад хүндэтгэлтэй хандах, гарцаар- ногоон гэрлээр гарах, кино үзвэр, хичээл сургууль, хурал цуглаанд гар утасныхаа дууг хаах, хогоо хогийн саванд хийж хэвших зэрэг арга хэмжээнүүдийг багтаасан)
- 5.3.2 “Хотын соёлд бидний оролцоо” санаачлагын ТУГ аялуулж, уриалсан, үлгэрлэсэн шинэ санаачлагуудыг сурталчлан, түгээн дэлгэрүүлэх
- 5.3.3. Орчны бохирдол ихтэй байгууллага, айл өрхийн гадаа анхааруулга /стикер/ нааж, хариуцлага тооцох
- 5.3.4. Иргэдийн хогоо ил задгай хаядаггүй хэвшлийг мөрдлөг болгох, хогийг ангилж авдаг байх зэрэг цогц арга хэмжээнүүдийг багтаасан “Хоггүй цэвэрч хот” аяныг өрнүүлэх
- 5.3.5. Сонгодог урлаг болон соёлын биет бус өвийн шавь сургалт зохион байгуулах
- 5.3.6. Дархан хотын соёлын брэнд – “Домог амилсан нутаг” дуулалт жүжигтэй болох
- 5.3.7. Авьяаслаг хүүхдийг Залуучууд театртэй гэрээгээр тэтгэлэгт хөтөлбөрт хамруулан сургах
- 5.3.8. “Хаадын түүх”, “Музей дэхь уламжлалт хөгжмийн зэмсгүүдийн тухай”, “Виртуал амьтад” төсөл хэрэгжүүлэн контент, урлагийн боловсрол олгох хөтөлбөр хэрэгжүүлэх
- 5.3.9. Оюутны урлагийн наадам, хүүхэд залуучуудын урлагийн наадмуудыг зохион байгуулж хүүхэд залуучуудын авъяас чадварыг нээн илрүүлэх

5.4. Соёлт хүн төрөлхтний эрхэм зүйл болох ном унших соёл, номтой нөхөрлөх хөдөлгөөнийг нийтэд түгээн дэлгэрүүлэх

- 5.4.1. ЕБС-ийн сурагчдын дунд “Номын сайн нөхөр” хөдөлгөөнийг улирал бүр тогтмол зохион байгуулах
- 5.4.2. Аймгийн удирдах ажилтнуудын дунд хагас жил тутам “Удирдах ажилтнуудын ширээний ном” уншлагын арга хэмжээг зохион байгуулах
- 5.4.3. Аймгийн төв номын сан, Хүүхдийн номын ордонд “Цахим уншлагын өрөө”, “Цахим номын сан” төслүүдийг хэрэгжүүлэх, 24 цагийн үйл ажиллагаатай номын сангийн үйлчилгээг бий болгох

5.4.4. “Оюунлаг Дарханчууд”, “Цахим номын хуудас”-ыг нээж тогтмол ажиллуулан хүүхэд, насанд хүрэгчид ном унших, харилцан мэдээлэл солилцох, интернэт орчин нөхцөлийг бүрдүүлж оролцогчдын хамрагдалтыг нэмэгдүүлэх;

5.4.5. Ном унших соёлыг түгээх, үндэсний онцлогийг илэрхийлсэн телевиз болон цахим “Номоор аялах цаг”, “Соён гэгээрэхийн чуулган” нэвтрүүлэг, контентуудыг бүтээж олон нийтийн хүртээл болгох;

5.4.6. Орчин цагийн хүүхдийн сэтгэхүйн онцлогийг тусгасан, тэднийг ном уншихад хөтлөх сонирхолтой сэдэв, чиглэлээр хүүхдийн бүтээлүүд туурвих;

5.4.7. Аймгийн төв номын сан, Насан туршийн боловсролын төв, Хүүхэд залуучуудын хөгжлийн ордон, Залуучуудын чөлөөт цагийн төвүүдэд идэвхтэй уншигчдын бүлгэм байгуулах замаар сурагч, оюутан, залуучууд, нийт иргэдийн дунд номтой нөхөрлөх хөдөлгөөн өрнүүлэх;

5.4.8. Дэлхийн болон үндэсний номын баяр, Дэлхийн хүүхдийн номын өдөр, Үндэсний бичиг үсгийн баярыг аймаг орон нутгийн хэмжээнд тогтмол тэмдэглэж, номын чуулган, яармаг, эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэг зохион байгуулж олон нийтийн хүртээл болгох;

5.4.9. Номын сангуудыг сан хөмрөгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд орон нутгаас тогтвортой дэмжлэх үзүүлэх, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хэрэгцээт номын судалгааг гарган “Ангийн номын сан”-г үе шаттайгаар баяжуулах

5.4.10. Аймгийн хэмжээнд жил бүр “Оюунлаг уншигч” байгууллага, анги хамт олон, аж ахуйн нэгж, иргэдийг шалгаруулан алдаршуулах, шагнаж урамшуулах;

5.4.11 Зохиолч, яруу найрагч, сэтгүүлчдийн ирээдүйг бэлтгэх зорилгоор утга зохиол, сэтгүүл зүйн дугуйлан секцийг хичээллүүлэх, “Оны шилдэг шүлэг” яруу найрагчдын наадмыг жил бүр зохион байгуулах, шилдэг бүтээлийн “Алтан өд” цуврал номыг хэвлүүлэх, “Зохиолч уншигчдын уулзалт”-ыг тогтмол зохион байгуулах;

5.5. Хүүхэд, залуучуудын оюуны чадамжийг хөгжүүлэх үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулах

5.5.1. Хүүхдүүдийн оюун ухааны суурь чадамжийг бэхжүүлэх, бүтээл болон шүүмжлэлт сэтгэлгээг хөгжүүлэх, гэр бүлийн хүрээнд хүүхдийг хөгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах

5.5.2. ЕБС-ийн бага ангийн нийт сурагчдад шатрын дугуйланг хичээллүүлэх

5.5.3. Оюуны хөгжлийн чадавхийг сайжруулах сургалтыг нийт цэцэрлэг, ЕБС-ийн бага ангийн сурагчдад хэрэгжүүлэх, үүнд: хэл, өгүүлэхүйн мэдрэмж, хараа, орон зайн мэдрэмж, хөдөлгөөн, тэнцвэрийн мэдрэмж, хэмнэл, сонсголын мэдрэмж, логик, харилцааны мэдрэмжид суурилсан авьяасыг нээн хөгжүүлэх арга зүй, технологийг тус тус боловсруулан хэрэгжүүлэх

Оюуны хөгжлийн 10 коэффициентийг хөгжүүлэх

- IQ - Тунгаан бодох, асуудлыг шийдвэрлэх, шинэ материал судлах чадвар
- EQ- Сэтгэл хөдлөл, харилцааны чадвар, зохицон ажиллах чадвар
- AQ-Бэрхшээлийг даван туулах, өөдрөг, зориг эрмэлзлэл өндөр байх
- CQ- Бүтээлч чадвараа зөв танин мэдэх, хөгжүүлэх

- SQ- Оюун санааны буюу сэтгэхүйн чадвар
- DQ- Бие бялдрын онцлогоо мэдэх, хөгжүүлэх, зорилгодоо хүрэх чадвар
- MQ- Хүний нийгэмд өөрийгөө зохицуулах чадвар
- NQ-Мэдээллийн сүлжээнд өөрийгөө захирах чадвар
- BQ- Эцэг эхчүүдийн үр хүүхдэдээ дотно харилцах чадвар
- FQ- Хөрөнгө мөнгийг оновчтой захирах чадвар

5.3.4.Аймгийн хэмжээний ОЮУНЫ СПОРТ-ын аварга сургууль, анги хамт олон, хувь хүмүүсийг шалгаруулж, урамшуулал олгох

5.3.5. Аймгийн хэмжээнд "ОЮУНЫ ИХ НААДАМ"–ыг 4 жилд нэг удаа зохион байгуулдаг уламжлал тогтоох

ЗУРГАА. ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮН

6.1. Иргэний шинжлэх ухааны бодлого төлөвлөгөөтэйгээр хөгжүүлэх боломж бүрдэнэ. Үр дүнд нь нийгмийн зүгээс шинжлэх ухаанд хандах хандлагыг өөрчлөх, шинжлэх ухааны хөгжилд иргэд олон нийтийн оролцоо нэмэгдэнэ. Аймгийн хэмжээний төсөл, хөтөлбөрүүдийг боловсруулахад Иргэний шинжлэх ухааны зөвлөлөөр хэлэлцүүлдэг байх журамд шилжинэ.

6.2 Их дээд сургуулиуд, политехник коллежууд, эрдэм шинжилгээний хүрээлэн төвүүдийн зүгээс иргэдийн зүгээс инновацид тулгуурласан бүтээгдэхүүн үйлчилгээ үйлдвэрлэдэг гарааны компани байгуулахад зөвлөгөө дэмжлэг үзүүлдэг болно.

6.3 Төрийн албан хаагчид "Хос бичигтэн" болсноор иргэд, олон нийтэд үлгэр үзүүлж, үндэсний бичгийн сургалт, хэрэглээ тогтмолжиж, бичиг соёлоо хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх зөв хандлага төлөвшинэ.

6.4. Өсвөр үе, хүүхдүүд залуучуудад эх түүхээ эрхэмлэх, ёс заншлаа дээдлэх, бусдыг хүндлэх, байгаль орчноо хайрлах ёс заншлыг түгээн дэлгэрүүлж хэвшил болгоно. Энэ хүрээнд нийгмийн хэм хэмжээ, соёлыг эзэмшүүлнэ.

6.5. Хотын соёл, хэв маягийг таниулах, дадах арга хэмжээг тасралтгүй зохион байгуулсны үр дүнд "Хоггүй-Найрсаг-Бусдыг хүндэлдэг Дарханчууд" амьдралын хэв маягийг төлөвшүүлнэ. Иргэдийн хотод амьдрах зөв хэвшлийг бий болгож, нийт олны эрх ашигт захирагдан, соёлжин гэгээрэх хандлагад ахиц гарна.

6.6. Иргэдийн ном унших хандлага нэмэгдэж, хүүхэд бүр ном унших дадал хэвшилтэй болсон байна.

6.7. Гэр бүлийн хүрээнд хүүхэдтэйгээ ажиллах хандлага нэмэгдэж, хүүхдийг хөгжүүлэх цогц сургалтуудыг зохион байгуулдаг болсон байна.

6.8 Хүүхэд залуучуудын дунд оюуны чадавхийг хөгжүүлэх сургалтууд тогтмолжиж, хүүхэд залуучууд ёс зүйн зохих боловсролтой, зөв цэгцтэй сэтгэх, өөрийгөө илэрхийлэх чадвартай болсон байна.

6.9 Тайзны ба бусад уран бүтээлийн төрөл, чанар сайжирч, үзэгч, уншигчдын оюуны хандлагад нийцсэн уран бүтээлийн нэмэгдсэн байна.

НАЙМ. ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

- Улс, орон нутгийн төсөв
- Олон улсын байгууллагын тусламж, хандив, төсөл
- Төрийн болон төрийн бус байгууллагын санаачлагаар хуримтлагдсан хөрөнгө
- Иргэд, аж ахуйн нэгж байгууллагын өөрийн хөрөнгө
- Бусад эх үүсвэр
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг нарийвчлан тодорхойлж, жил бүрийн төсөвт тусгана.

ЕС. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

9.1 Боловсрол соёл урлагийн газар нь хөтөлбөрийн хэрэгжилтийн бодлого, төлөвлөлтөөр хангах явцын хяналт шинжилгээ хийх үүргийг хүлээнэ. Хөтөлбөрийн хэрэгжилтийг төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хүрэх үр дүн болон шалгуур үзүүлэлтийн биелэлтээр тооцож гаргана.

9.2 Хөтөлбөрийн хэрэгжилтэнд дэмжлэг үзүүлэх, орон нутгийн онцлогт нийцүүлэн хэрэгжүүлэх, санхүүжүүлэх үүргийг аймгийн Засаг дарга, түүний тамгын газар хариуцна.

9.3 Оюунлаг иргэнийг төлөвшүүлэх, хөгжүүлэх, бүтээлч үйл ажиллагааг дэмжихэд мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтарч ажиллах үүргийг аймгийн Боловсрол Соёл Урлагийн Газар хариуцна.

9.4 Хөтөлбөрийн хэрэгжилтэнд үр дүнгийн хяналт шинжилгээ үнэлгээг жил тутамд аймгийн ЗДТГ-ын ХШҮДАХэлтэс хийнэ.

БОЛОВСРОЛ СОЁЛ УРЛАГИЙН ГАЗАР